



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 29

Мандалговь

Сонгуулийн зурагт самбар, дэлгэц  
байрлуулах байршлыг тогтоох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан суманд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэцийг нийтийн эзэмшлийн гудамж талбай, олон нийтийн газарт байрлуулах байршлыг дор дурдсанаар тогтоосугай.

Үүнд : 1.Г. Чагдаржавын гудамж

2.Ж.Наранцацралтын гудамж

3.С.Буяннэмэхийн өргөн чөлөө

4.Найрамдалын гудамж

5.Худалдааны гудамж-1 /Хүмүүнлэг сургуулийн спорт заалны урдах уулзвараас баруун тийш Чагдаржавын гудамжны уулзвар хүртэл/

6. Их тойруугийн зам дагуу

7.Бага тойруугийн зам дагуу /Буянт гүүрнээс Жаст ойл ШТС-ын уулзвар хүртэл/

8.Мандал худалдааны талбай

9.Номгон худалдааны талбай

10.Баруун лагерийн худалдааны талбай

11.Зүүн лагерийн худалдааны талбай

12.Жаст ойл ШТС-аас баруун тийш Мандалын 10-р гудамжны засмал

зам дуустал

13.Баруун лагерт шинээр тавьсан босоо засмал зам дагуу

14.Зоогийн 1-р гудамжны өмнөх засмал зам дагуу

15.Арвижих-Зоогийн гудамжны голоорх дээшээ чиглэлтэй зам дагуу

16.Арвижихын-5-р гудамжны өмнөх засмал зам дагуу

2.Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн заалтуудыг мөрдөж, дээрх нэр заасан гудамж, талбай, газарт сонгуулийн сурталчилгааны материалыг байршуулж, орчныг бохирдуулахгүй, замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Намуудын дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ

D:/ITKHural/Terguulegch. togtool.04.07